



**ЦУС СЭЛБЭЛТ СУДАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ**





**Ж-2-ЕР-18-03**

**ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮССЭН ТОХИОЛДЛЫГ  
БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЖУРАМ**

**ЭХ ХУВЬ 1**

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-04		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт орвчлсан	Хуудас 1/ 18



Боловсруулсан:	Өөрчлөлт оруулсан:	Хянасан:	Баталсан:
ТБХАХАСБ-ын багийн дарга, нарийн бичиг	ТБХАХАСБ-ын багийн нарийн бичиг	ЦЧАБА-ийн албаны дарга	ЦССҮТ –ийн захирал
Н.Өлзийсайхан Б.Соёлоо	Н.Өлзийсайхан Б.Соёлоо	Т.Алимаа	Н.Эрдэнэбаяр
Огноо:2018.05.15	Огноо:2021.05.05	Огноо:2021.05.17	Огноо:
Гарын үсэг 	Гарын үсэг 	Гарын үсэг 	Гарын үсэг 



Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-3		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхлэсэн	Өөрчлөлт-3	Өөрчлөлт	Хуудас 2/18

# 1. ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

Д.д	Хуудас №	Бүлэг №	Өөрчлөлт оруулсан огноо	Оруулсан өөрчлөлтийн утга	Шалтгаан	ЧАД-ын гарын үсэг
1	5	2	2021.05	Тодорхойлолт	ЭМС-ын 2019 оны А/566 тоот тушаал	
2	5	2	2021.05	Товчилсон үг	ЭМС-ын 2020 оны А/445	
3	5	3	2021.05	Зорилго	ЭМС-ын 2019 оны А/566 тоот тушаал	
4	5-7	5	2021.05	Хариуцлага, эрх үүрэг	ЭМС-ын 2019 оны А/566 тоот тушаал	
5	7-13	6	2021.05	Журмаар зохицуулах үйл ажиллагаа	ЭМС-ын 2019 оны А/566 тоот тушаал	
6	13	7	2021.05	Лавлах иш татсан материал	ЭМС-ын 2019 оны А/566 тоот тушаал	
7	13-18	8	2021.05	Хавсралт	ЭМС-ын 2019 оны А/566 тоот тушаал	

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг					
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03			Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05	Хуудас 3/ 18	

## 1. Агуулга

Д/д	Бүлэг	Хуудас
1.	Өөрчлөлт оруулсан бүртгэл	3
2.	Тодорхойлолт, товчилсон үг	5
3.	Зорилго	5
4.	Хамрах хүрээ	5-7
5.	Хариуцлага, Эрх үүрэг	7-13
6.	Журмаар зохицуулах үйл ажиллагаа	13
7.	Лавлах иш татсан материал	13
8.	Хавсралт	13-18

## 2. Тодорхойлолт, товчилсон үг, шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл

### 2.1 Тодорхойлолт

- 2.1.1 **Тохиолдол**- Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд аюулгүй байдалд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй байдал –анхаарал татсан нөхцөл байдал үүсэх
- 2.1.2 **Алдах дөхсөн тохиолдол** – Үйлчлүүлэгчдэд хохирол учруулж болзошгүй байсан ч таслан зогсоосон үйлдэл
- 2.1.3 **Таагүй тохиолдол**- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчдэд сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдал үүсэх
- 2.1.4 **Ноцтой тохиолдол** -Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгч ноцтой хохирох, эсвэл амь насаа алдахад хүргэсэн үр дагавар
- 2.1.5 **Эмнэлгийн алдаа** -Төлөвлөсөн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх, эсвэл буруу төлөвлөн хэрэгжүүлсэн, зөв төлөвлөсөн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэн үйлдэл

### 2.2 Товчилсон үг

ЦССҮТ-цус сэлбэлт судлалын үндэсний төв

ЦЧАБА цусны чанар аюулгүй байдлын алба

УЗ-Удирдлагын зөвлөл

АТТ- Албан тушаалын тодорхойлолт

САЗ-стандарт ажиллагааны заавар

ТТСАЗ-тоног төхөөрөмжийн стандарт ажиллагааны заавар

ТБ –Тохиолдлын баг /Төвийн орон тооны бус тохиолдлын баг/

## 3 Зорилго

Энэ журмын зорилго нь ЦССҮТ-ийн /цаашид “Төв” гэх/ тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудыг (цаашид тохиолдол гэх) бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, давтан гарахаас сэргийлж, тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад оршино.

## 4 Хамрах хүрээ

Энэхүү журмыг төвийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид дагаж мөрдөнө.

## 5 Хариуцлага, Эрх үүрэг:

5.1 Төвийн удирдлага нь Багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хэлэлцэн баталгаажуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлагын дүн шинжилгээ хийх, дэмжлэгт удирдлагаар хангах үүрэгтэй.

### 5.2 Цусны чанар, аюулгүй байдлын алба:

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05	Хуудас 5/ 18

- 6.2.1. Чанарын менежер нь төвийн орон тооны бус албыг удирдаж, тохиолдлыг илрүүлэх бүртгэх, мэдээлэх, засах, сэргийлэх журмыг төвийн үйл ажиллагаанд нийцүүлэн боловсруулж, төвийн эмч, ажиллагсад сургал зохион байгуулж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.
- 6.2.2. Төвийн үйл ажиллагаанд илрүүлсэн тохиолдлын мэдээллийн сан үүсгэж, думдлагын баг, ЭМХТ-д тогтмол мэдээлэл хүргэнэ.
- 6.2.3. 2,3-р зэрэглэлд хамаарагдах тохиолдлыг хэлэлцэн, байгууллагын удирдлагад мэдээлнэ.
- 6.2.4. Шаардлагатай тохиолдолд дүн шинжилгээний багийг томилно.
- 6.2.5. 3-р зэрэглэлийн тохиолдлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

### 5.3 Тасгийн эрхлэгч, албаны дарга нар:

- 6.3.1 Эмч, ажиллагсдын илрүүлсэн тохиолдлыг шуурхай хүлээн авч, зэрэглэнэ. 1А, 1Б зэрэглэлийн тохиолдлыг алба, тасгийн түвшинд тохиолдлыг хэлэлцэж авсан хариу арга хэмжээ, шийдвэрлэсэн байдалд хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг ЦЧАБ-ын албанд мэдээлнэ.
- 6.3.2 Тасаг, алба дээр гарсан тохиолдлын санг үүсгэн, шалтгааныг арилгах, давтан гаргахаас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, байнгын хяналт тавина.
- 6.3.3 Үйл ажиллагаанд илэрч болох тохиолдлыг урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

### 5.4 Төвийн нийт ажиллагсад:

- 5.4.1. Төвийн нийт ажилтнууд Багийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах;
- 5.4.2. Үйл ажиллагаа, ажилбар бүрд мөрдөх журам, зааврыг сайтар судлан чанд мөрдөж ажиллах, тохиолдлын журмыг судлаж танилцан хэрэгжүүлэх
- 5.4.3. Тохиолдлыг илрүүлж, маягыг бөглөн шуурхай мэдээлэх;
- 5.4.4. Тохиолдлыг залруулах арга хэмжээг зохион байгуулах үүрэг авсан бол зааврын дагуу гүйцэтгэж, үр дүнг тасгийн эрхлэгч, албаны даргад мэдээлнэ.

### 5.5 Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг:

#### 5.5.1 Дарга:

- Багийн үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу нэгтгэн, зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, тайлагнана.
- Улирал бүр төвийн хэмжээнд тохиолдсон тохиолдлыг нэгтгэн дүгнэж, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг дүгнэн үр дүнг удирдлагын зөвлөл, ЦЧАБА-д мэдээлнэ.
- Төвийн удирдлагын дүн шинжилгээнд тохиолдлын тогтолцооны хэрэгжилт, үр дүнг сайжруулах саналыг хэлэлцүүлнэ, Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

#### 5.5.2 Нарийн бичиг:

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн	Өөрчлөлт-3	Өөрчлөлт	Хувилас 6/18

- Хурлыг зарлан хуралдуулах, хурлын тэмдэглэл хөтлөх.
- Төвийн хэмжээний тохиолдлыг улирал бүр нэгтгэж багийн даргад мэдээлнэ.
- Багийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнана.

### 5.5.3 Гишүүд:

- Журмын хэрэгжилтийг манлайлан, алба, тасгийн өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавина.
- Журмыг алба, тасгийн ажлан бүрд таниулах сургалт зохион байгуулж, баримтжуулна.
- Алба, тасагт бүртгэгдсэн тохиолдолд дүн шинжилгээ хийж, засах, сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.
- Улирал бүр /дараа улирлын эхний сарын 5-ны дотор/ алба, тасагт бүртгэгдсэн тохиолдол, авсан арга хэмжээг нэгтгэж багийн нарийн бичгийн даргад мэдээлнэ.

## 6 Журмаар зохицуулах үйл ажиллагаа

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудыг (цаашид тохиолдол гэх) бүртгэж, дүн шинжилгээ хийх, шалтгааныг тогтоох, мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой асуудлыг энэ журмаар зохицуулна.

### 6.1 Тохиолдлуудын үндсэн шалтгаан

Энэхүү журмын 5.1-д заасан тохиолдлуудын үндсэн шалтгааныг дараах байдлаар тодорхойлно.

- 5.3.1. Үйлчлүүлэгчийн танин тодруулга
- 5.3.2. Харилцааны дутагдал, доголдол
- 5.3.3. Эмийн аюулгүй байдал
- 5.3.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний халдвар
- 5.3.5. Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унасан
- 5.3.6. Бусад шалтгаан

### 6.2 Тохиолдлуудын нөлөөлөх хүчин зүйл

Энэхүү журмын 5.1-д заасан тохиолдлуудын нөлөөлөх хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлно.

- 5.4.1. Үйлчлүүлэгчийн хүчин зүйл
- 5.4.2. Хувь хүн/ ажилтны хүчин зүйл
- 5.4.3. Ажлын болон үйлчилгээний орчны хүчин зүйл
- 5.4.4. Багийн хүчин зүйл

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05	Хуудас 7/ 18



- 5.4.5. Баримт бичиг/технологийн хүчин зүйл
- 5.4.6. Бүтэц, зохион байгуулалтын хүчин зүйл

### 6.3 Тохиолдлыг илрүүлэх

- Тухайн алба, тасгийн ажилтны өөрсдийн хяналт, ажиглалтаар;
- Тухайн алба, тасаг нэгжийн удирдлагын хяналтаар;
- Төвийн удирдлага, ЦЧАБА-ны дарга болон бие даасан зөвлөх экспертүүдийн хяналтаар;
- Мэргэжлийн болон бусад хяналтын байгууллагаас хийсэн хөндлөнгийн шалгалт ;
- Гадаад дотоод аудитын үзлэгээр;
- Гэрээлэгч/захиалагч, үйлчлүүлэгчээс ирүүлсэн санал шүүмжлэлээр

### 6.4 Тохиолдлыг бүртгэх, мэдээлэх ерөнхий зарчим

- 6.4.1 Төвийн ажилтан бүр тохиолдлыг шуурхай мэдээлэнэ.
- 6.4.2 Тохиолдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийлгүйгээр ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэхгүй.
- 6.4.3 Тохиолдол мэдээлэх, бүртгэх, үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх бүхий л үйл ажиллагаа баримтжуулагдсан байна.
- 6.4.4 Тохиолдлын нэгдсэн сангийн ажиллах журмын дагуу эрүүл мэндийн байгууллагын эрх бүхий ажилтан мэдээлэл илгээнэ. Сангаас мэдээллийг төвд олгогдсон эрхийн дагуу эрүүл мэндийн ажилтан бүр нэвтэрч мэдээлэл авч болно.
- 6.4.5 Мэдээлэгдсэн тохиолдлууд мэргэжлийн индексийн дагуу тохиолдлын нэгдсэн санд бүртгэгдэнэ.
- 6.4.6 Тохиолдлын нэгдсэн санд бүртгэгдсэн тохиолдлууд нь хэрэглэгчдэд орон нутаг, эрүүл мэндийн байгууллагын нэр, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчийн нэр хаяггүйгээр гарсан тохиолдол, шийдвэрлэсэн арга зам хэлбэрээр харагдах бөгөөд зөвхөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, харилцан суралцах, туршлагаа хуваалцах зорилгоор хэрэглэгдэнэ.
- 6.4.7 Тохиолдлыг илрүүлэн мэдээлсэн ажилтныг зэмлэн буруутгах бус, эерэг бүтээлч арга замаар асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагаанд оролцсонд тооцно.

### 6.5 Тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, ангилах

#### 6.5.1 Бүртгэн мэдээлэх

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн	Өөрчлөлт-3	Өөрчлөлт	Хуудас 8/ 18

- Тохиолдлыг анх харсан, оролцсон, илрүүлсэн ажилтан **“Тохиолдол, хариу арга хэмжээний бүртгэл”** – ийг бөглөж тасаг нэгжийнхээ ТБХАХАСБ-ийн гишүүн эсвэл эрхлэгчид мэдээлнэ.
- Тухайн алба, тасагтай холбоогүй тохиолдол бол **“Тохиолдлыг мэдээлэх хуудас”**-ны А хэсэг болон **“Тохиолдол, хариу арга хэмжээний бүртгэл”** – ийг тус тус бөглөж, холбогдох алба, тасгийн ТБХАХАСБ-ийн гишүүн эсвэл эрхлэгчид мэдээлэх хуудсыг хүлээлгэн өгнө.
- Тохиолдол мэдээлэх хуудсыг цаасан хэлбэрээр алба тасаг/нэгж бүрт байршуулана.

**Тохиолдлыг тасаг нэгжид бүртгэх мэдээлэх хуудас М-4-ЦЧАБА- 8**

- 6.5.2** Тухайн алба тасагт гарсан бүх тохиолдолдыг дугаарлана. Тохиолдлын дугаар нь дахин давтагдахгүй дугаар байна.
- 6.5.3** Бүртгэгдэж мэдээлэгдсэн тохиолдлыг ТБХАХАСБ болон багийн гишүүд ангилан цаашид авах арга хэмжээний чиглэлийг гаргана.
- 6.5.4** Энэ журмын 5.1.1 –д заасан нөхцөл байдал үүссэн бол 1А гэж бүртгэн тасаг/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг тохиолдлын багт мэдээлнэ.
- 6.5.5** Энэ журмын 5.1.2 –т заасан алдах дөхсөн тохиолдолд түүнийг 1Б гэж бүртгэн тасаг/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг тохиолдлын багт мэдээлнэ.
- 6.5.6** Энэ журмын 5.1.3 –т заасан таагүй тохиолдолд түүнийг 2 гэж бүртгэн, ЦЧАБА болон ТБХАХАСБ хэлэлцэн байгууллагын удирдлагад мэдээлнэ.
- 6.5.7** Энэ журмын 5.1.4 –т заасан ноцтой тохиолдолд түүнийг 3 гэж бүртгэн ЦЧАБА болон ТБХАХАСБ төвийн удирдлагад мэдээлж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.
- 6.5.8** Энэ журмын 5.1.5 –т заасан Эмнэлгийн алдаа гэж тогтоогдсон бол холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.
- 6.5.9** Тохиолдлын нэгдсэн сангийн ажиллах журмын дагуу төвд олгосон эрх бүхий бүхий ажилтан мэдээлэл илгээнэ.
- 6.5.10** Тохиолдлын үр дагаварын ангилал, мэдээлэх түвшин

Ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Тохиолдлын зэрэглэл	Тохиолдлын үр дагаварын ангилал	Авах арга хэмжээ, мэдээлэл түвшин
---------	-------------------------	---------------------	---------------------------------	-----------------------------------

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05	Хуудас 9/ 18

Тохиолдол	Анхаарал татсан нөхцөл байдал үүсэх	1А	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид гэмтэл учруулаагүй, аюулгүй байдал, байгууллагын нэр хүндэд нөлөөлөөгүй	Тасаг нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг ТБХАХАС багт мэдээлнэ
Алдах дөхсөн тохиолдол	Хор хөнөөлд хүргэж болзошгүй байсан ч таслан зогсоосон үйлдэл	1Б		
Таагүй тохиолдол	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчид сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдал үүсэх	2	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт, гэмтэлийн хэмжээ бага	ЦЧАБА хэлэлцэн байгууллагын удирдлагад мэдээлнэ.
Ноцтой тохиолдол	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөнд бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах, эсвэл амь насаа алдахад хүргэсэн ямар нэг урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүсэх	3	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт үзүүлсэн, хор уршиг учруулаагүй боловч гомдоосон, байгууллагын нэр хүндэд нөлөөлсөн	

6.5.11 Тохиолдлыг илрүүлж, бүртгэж, хяналтад авах нь мэргэжлийн алдаатай хариуцлагагүй үйлдлийг таслан зогсоох, дагалдан гарах таагүй үр дагавар, цаашид дахин давтагдахаас сэргийлэхэд чиглэгдэж байгаа болно.

## 6.6 Шат дамжлага бүрт гарч болзошгүй тохиолдлын төрөл

### 6.6.1 Цус цуглуулах үйл ажиллагааны:

- Донорын бүртгэл хийх шаардлага дутуу биелэгдэх
- Донорыг танин тодруулах шаардлага хангагдаагүй байх
- Донорын зүгээс шаардлага хангагдахгүй байх /судас хагарах, дахин хатгах /
- Донорын тохой халдваргүйтгэл дутуу байх
- Асуумж үзлэг хангалтгүй байх
- Сорьц цуглуулах ажиллагааны шаардлага хангагдахгүй байх /сорьц дутуу авах, буруу авах, уусмалтай сорьц авах/
- Цус цуглуулах хэмжээ шаардлага хангахгүй байх
- Донорын бар код давхцах
- Келл эерэг байнгын донороос цус цуглуулах
- Аппарат тоног төхөөрөмжийн эвдрэл, догодол
- Явуулаар цус цуглуулах үйл ажиллагааны бэлтгэл байдал хангагдахгүй байх
- Сургалт сурталчилгаагаар дутуу, буруу мэдээлэл өгөх. . . гэх мэт

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн	Өөрчлөлт-3	Өөрчлөлт	Хувдас 10/18

6.6.2 Шинжлэх үйл явцын:

- Шинжилгээний стандарт ажиллагааны зааврыг мөрдөөгүй байх
- Шинжилгээний хариу заасан хугацаанд гарахгүй байх
- Шинжилгээний протокол хөтлөгдөхгүй байх
- Мөшгөн тогтоох боломжгүй байх
- Шинжилгээний буруу үр дүнг үйлчлүүлэгчид олгох
- Урвалж оношлуурын тасалдал, үйл ажиллагааны доголдол
- Аппарат тоног төхөөрөмжийн эвдрэл
- Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хангалтгүй дүнтэй оролцох
- Цусны урвуу болон шууд аргын зөрөөтэй байдал ...

6.6.3 Үйлдвэрлэх явцын:

- Бүтээгдэхүүн хадгалалтын шаардлага үл биелэгдэх
- Гэрээний заалтыг зөрчих;
- Гэрээнд заасан хугацааг хоцроох
- Тоног төхөөрөмжийн эвдрэл, доголдол
- Цахим сүлжээний мэдээллийг буруу оруулах
- Бүтээгдэхүүний жингийн зөрүү ....

6.6.4 Дэмжих үйл ажиллагааны:

- Дэмжих үйл ажиллагааны нөөцийн тасалдал
- Сорьц, бүтээгдэхүүн тээвэрлэх явцын алдагдал
- Үйл ажиллагаанд хэрэглэгдэх материалын сонголтын шаардлага хангагдахгүй байх
- Тогтоосон хугацаанд шаардлагатай материалаар хангахгүй байх
- Цэвэрлэгээ үйлчилгээний шаардлага хангагдахгүй байх
- Ариутгал, халдваргүйтгэл, угаалгын шаардлага хангагдахгүй байх
- Ажилчдын цалин хугацаандаа орохгүй байх
- Тайлан мэдээг хугацаанд нь илгээхгүй байх
- Дулаан, ус хангамж тасалдах
- Баримт бичгийг архивлах үйл явцын алдаа
- Хүний нөөц дутагдалтай байх
- Хавсран болон орлон ажилах
- Ур чадваргүй байх
- Ажилбарын гүйцэтгэл дутуу байх ....

6.6.5 Цахим сүлжээ, эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж холбоотой:

- Мэдээлэл хуулагдахгүй байх

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05	Хуудас 11/ 18

- Мэдээлэл тасаг хооронд дамжихгүй байх
- Цахимаар тайлан тооцоо гарахгүй байх
- Цахимаар баталгаажилт хийгдэхгүй, гацах
- Цахим сүлжээнд нэвтрэх боломжгүй болох
- Тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагаа
- Хэмжих хэрэгсэлтэй тоног төхөөрөмжийн баталгаажилт хийгдэхгүй байх ....

### **6.7 Тохиолдлыг бүртгэсний дагуу авах арга хэмжээ:**

- 6.7.1** 1А, 1Б ангилалд хамаарах тохиолдлыг тасаг/нэгжид сургалт зохион байгуулах, тохиолдол гарах шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг арилгах, эрсдэлээс сэргийлэх зэрэг арга хэмжээ авч, ТБХАХАСБ-т мэдээлнэ.
- 6.7.2** 1А, 1Б ангилалд хамаарах тохиолдлыг ажилтан ажлын явцад залруулах, арилгах арга хэмжээ авч, үр дүнг шалган баримтжуулна.
- 6.7.3** Тохиолдол нь 2,3 ангилалд хамаарагдаж байвал ЦЧАБА-ын алба нь дүн шинжилгээний багийг зохион байгуулна.
- Дүн шинжилгээний багт тухайн чиглэлээр мэргэшсэн болон ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус шийдвэр гаргах чадвартай мэргэжилтнүүдийг сонгох ба тогтолцоо, үйл явц, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн зөвлөмж, дүгнэлт гаргана.
  - Баг нь хариу арга хэмжээний төлөвлөгөөг дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн боловсруулж хэрэгжилтийг ханган тайлагнана.
- 6.7.4** Шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн хяналт хийх дүн шинжилгээний багийг Эрүүл мэндийн яам томилон ажиллуулж болно.
- 6.7.5** Нийгмийн сүлжээгээр түгээгдсэн төвийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээллийг ЦЧАБА-ийн алба тохиолдол гэж бүртгэх бөгөөд дүн шинжилгээ хийж хариу арга хэмжээ авна. Тохиолдлын зэрэглэлээс хамаарч тасаг/нэгж авсан арга хэмжээ, дүн шинжилгээ хийсэн дүгнэлтийг холбогдох албан тушаалтан, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, үйлчлүүлэгчид хууль, журмын дагуу эргэн мэдээлнэ.
- 6.7.6** ТБХАХАСБ нь хагас бүтэн жилээр бүртгэгдэн шийдэгдсэн тохиолдлуудад дүгнэлт хийн, удирдлагын багаар хэлэлцэн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган ажиллана.
- 6.7.7** Олон дахин давтагдсан тохиолдлыг ТБХАХАСБ-ийн хурлаар хэлэлцэж, залруулах, арилгах арга хэмжээ авч баримтжуулна.


### **6.8 Тохиолдлыг дахин гарахаас сэргийлэх**

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн	Өөрчлөлт-3	Өөрчлөлт	Хувдас 12/18

- 6.8.1 Тохиолдлыг дахин гарахаас сэргийлэх арга хэмжээ нь ажилтанг шийтгэхэд чиглэх бус харин шалтгаан нөхцөлийг судлах, эрсдлийг арилгах, бууруулахад чиглэх ёстой юм.
- 6.8.2 1А, 1Б зэрэглэлийн тохиолдлыг алба, тасгийн хэмжээнд судлан, шалтгаан нөхцөлийг тодруулж, хамт олны хурлаар хэлэлцэн сэргийлэх арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлнэ.
- 6.8.3 2,3-р зэрэглэлийн тохиолдлыг ТБХАХАСБ болон ЦЧАБА хамтран судалж, шалтгаан нөхцөлийг тодруулж, сэргийлэх арга хэмжээг тодорхойлон Төвийн захирал болон УЗ-д санал хэлэлцүүлж, хэрэгжүүлнэ.
- 6.8.4 Сэргийлэх арга хэмжээ нь тохиолдлын давтамж, хэмжээ, шалтгаан, нөхцөл, ажлын байр зэргээс хамааран дараах төрөлтэй байна. Үүнд:
- Алба, тасгууд тухайн тохиолдол гарсан ажилбар, бүтээгдэхүүн, үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан баримтжуулсан бичиг баримтын агуулгаар дотоод сургалт зохион байгуулах
  - Шаардлагатай бол баримтжуулсан бичиг баримтад өөрчлөлт оруулах
  - Ажилтныг дагалдуулан сургах, дадлагажуулах
  - Ажлын байрны шинжилгээ хийх
  - Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх
  - Анхааруулга, санамж байршуулах
  - Нийт ажилтнуудад ижил төрлийн тохиолдол гарахаас зайлсхийх мэдээлэл, сануулга өгөх
  - Гар ажиллагаа, хүний алдааг багасгах санал боловсруулах
  - Шинэ технологи, аргачлал нэвтрүүлэх
  - Бусад шинэ арга, хэлбэр, санаачилга
- 7. Лавлах иш татсан материал**
- ЦССҮТ–ийн Чанарын гарын авлага
  - Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566 дугаар тушаал
- 8. Хавсралт.**
- Хавсралт 1. Тохиолдлыг мэдээлэх, бүртгэх үйл явц
  - Хавсралт 2. Тохиолдол мэдээлэх хуудас, бөглөх заавар

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05	Хуудас 13/ 18

**Хавсралт1.** Тохиолдлыг мэдээлэх, бүртгэх, хариу арга хэмжээ авах үйл явц



**Хавсралт 2.** Тохиолдол мэдээлэх хуудас, бөглөх заавар

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн	Өөрчлөлт-3	Өөрчлөлт	Хуудас 14/18

А.Хэсэг. Ажилтан бөглөнө	
Байгууллагын нэр.....	
Тохиолдол болсон байршил.....	
Цаг.....	
Огноо.....он .....сар.....өдөр	
Тохиолдсон явдал.....	
.....	
Мэдээлсэн ажилтан:.....	
/нэр/	/гарын үсэг/
Танилцсан:	
ТБХАХАСБ-ийн гишүүн: :.....	
/нэр/	/гарын үсэг/

Б.Хэсэг. Хамаарах тасаг нэгжид илгээнэ.	Тохиолдлын №.....
Тасаг нэгж:	
Шалтгаан: Хувь хүнтэй холбоотой	Тогтолцоотой холбоотой <input type="checkbox"/>
Тохиолдлын зэрэг: 1А 1Б	
Тохиолдлын үндсэн шалтгаан: /журмын 5.3 харна/	
Нөлөөлөх хүчин зүйл: /журмын 5.4 харна/	
Тасаг нэгжээс авсан арга хэмжээ:	
Тасгийн эрхлэгч:.....	.....
/нэр/	/гарын үсэг/
Танилцсан:	
ТБХАХАСБ-ийн гишүүн: :.....	.....
/нэр/	/гарын үсэг/
Огноо.....он .....сар.....өдөр	

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05	Хуудас 15/ 18



**ТБХАХАСБ-т хөтлөгдөх тохиолдлын хуудасны загвар**

**М-4-ЦЧАБА- 9**

<p>А.Хэсэг. ТБХАХАСБ бөглөнө.</p> <p>Тасаг нэгж:</p> <p>Тохиолдсон явдал</p> <p>Тохиолдлын зэрэг: /журмын 5.1, 7.5.5 харна/</p> <p style="text-align: center;">2      3</p> <p>Шалтгаан: /журмын 5.3 харна/ 1 2 3 4 5 6</p> <p>Нөлөөлөх хүчин зүйл: /журмын 5.4 харна/ 1 2 3 4 5 6</p> <p>Хэрэгжүүлсэн арга хэмжээ:</p> <p>Чанар сайжруулах арга хэрэгсэл:</p> <p>Эргэх холбоо: /дугуйлна уу/</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын удирдлагад</li> <li>2. Тохиолдол мэдээлсэн ажилтанд</li> <li>3. Үйлчлүүлэгч, түүний ар гэрт</li> <li>4. Холбогдох эрүүл мэндийн байгууллагад</li> <li>5. Эрүүл мэндийн хөгжлийн төв</li> </ol> <p>ТБХАХАСБ-ын дарга:.....</p> <p style="text-align: center;">/нэр/</p> <p>Огноо.....он .....сар.....өдөр</p>	<p>Тохиолдлын №.....</p> <p style="text-align: center;">Нийгмийн сүлжээгээр түгээгдсэн</p> <p style="text-align: center;">.....</p> <p style="text-align: center;">/гарын үсэг/</p>
---	---

**Тохиолдлыг бүртгэх хуудас бөглөх заавар**

**Байгууллагын нэр:** Өгсөн зайд тухайн эмнэлэг, байгууллагын нэрийг бичнэ.

**Байршил:** Тохиолдол болсон тасаг/нэгжийг бичнэ. Нэгээс илүү тасгийн нэр бичиж болно.

**Тохиолдол болсон огноо:** Тохиолдол болсон огноог өдөр/сар/он/ гэсэн форматаар бичнэ. Эргэлзэж байгаа үед өдрийг ойролцоогоор бичиж болно.

**Тохиолдол болсон хугацаа:** Тохиолдол болсон хугацааг / цаг /минут форматаар бичнэ. Эргэлзэж байгаа үед хугацааг ойролцоогоор бичиж болно.

**Тохиолдол:** Тухайн тохиолдол хэрхэн гарсан, тохиолдохоос өмнө буюу тухайн үед болж байсан үйл явцын талаар бичнэ. Тохиолдол гарахад хүргэж болзошгүй нэмэлт мэдээллийг бичиж болно.

**Мэдээлсэн хүний нэр:** Нэрийг гаргацтай тод бичиж, гарын үсгээ зурна

**Албан тушаал:** Эрхэлдэг албан тушаалаа бичнэ.

**Тохиолдлын дугаар:** ЭМТҮЧАБ-ын алба/багаас тохиолдлын дугаар анна.

**Тасаг/нэгж:** Тохиолдол гарсан, тохиолдолтой холбоотой тасаг/нэгжийн нэрийг бичнэ.

**Тохиолдлын шалтгаан:** Үндсэн шалтгааныг илрүүлэх дүн шинжилгээ хийн шалтгааныг тодорхойлсон тухай бичнэ. Тухайн тохиолдол хувь хүнтэй холбоотой, тогтолцоотой холбоотой аль нь болохыг сонгож бичнэ.

**Тохиолдлын зэрэг:** 1А, 1Б, 2, 3 гэсэн зэрэглэлд аль хамаарахыг дугуйлж тэмдэглэнэ.

**Тасаг/нэгжээс авсан арга хэмжээ:** Тохиолдлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс, үр дагаварыг арилгах, дахин давтагдахаас сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ. Мөн бусад тасаг/нэгжүүдэд ийм төрлийн тохиолдол давтагдахаас сэргийлсэн үйл ажиллагааг чанар аюулгүй байдлын алба /багтай хамтран зохион байгуулсан талаар бичиж болно.

**Гарын үсэг:** тод гаргацтай, тайллын хамт бичигдсэн байна.

**Шалтгаан:** Үндсэн шалтгааныг илрүүлэх дүн шинжилгээний дүнд тохиолдол гаргахад хүргэсэн шалтгаан гэж тодорхойлсныг бичнэ.

**Нөлөөлөх хүчин зүйл:** үндсэн шалтгааныг илрүүлэх дүн шинжилгээний дүнд тохиолдол гаргахад нөлөөлсөн хүчин зүйл гэж тодорхойлсныг бичнэ.

**Хэрэгжүүлсэн арга хэмжээ:** ЭМТҮЧАБ-ын алба/баг байгууллагын удирдлагатай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ.

**Чанар сайжруулах арга хэрэгсэл:** Ийм тохиолдол давтагд мэдээллийг түгээх, бусад тасаг / нэгж/-д тохиолдол гарах шалтгаан зүйл байгаа бол арилгуулах арга хэрэгсэл хэрэглэснийг бичнэ.

**Эргэх холбоо:** Эргэх холбоо тогтоон хариу мэдээлэл хүргэсэн байгууллага, хувь хүнийг сонгон тэмдэглэл хийнэ.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг				
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-03		Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №01	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05	Хуудас 17/ 18

Тохиолдол, хариу арга хэмжээний бүртгэл

М-4-ЦЧАБА-10

д	Огноо цаг минут	Тохиолдол	Тохиолдлын шалтгаан	Илрүүлсэн ажилтан	Тохиолдол гаргасан ажилтан	Залруулсан хэмжээ	арга	Сэргийлсэн арга хэмжээ	Хянасан тасгийн эрхлэгч	алба,

Жич: Тасаг нэгж дээр бүртгэгдсэн тохиолдлын дэс дугаар нь тухайн тохиолдлын дугаар болно.

М-4-ЦЧАБА-11

д	Огноо цаг минут	Тохиолдол	Илрүүлсэн ажилтан	Тохиолдлыг бүртгэх хуудсыг		
				хүлээлгэн өгсөн ажилтан	хүлээн ажилтан	авсан

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх баг		
Баримт бичгийн № Ж-2-ЕР-18-3 Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, сэргийлэх журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхлэсэн огноо: 2018.05.15	Өөрчлөлт-3 Хуудас 18/ 18
		Өөрчлөлт оруулсан огноо: 2021.05.05

